



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/96

Цагаан-Уул сум

**Хагас жилийн малын түүвэр судалгаа  
явуулах тухай**

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйл, малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хагас жилийн малын түүвэр судалгааг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.
2. Малын түүвэр судалгааг сумын хэмжээнд зохион байгуулах комиссыг 1 дүгээр хавсралтаар, түүвэр судалгаа явуулах удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Судалгаа, тооллогын ажлыг харьяа багаас сонгогдож ирсэн бүх өрхийг бүрэн хамруулж, нүдээр үзэн тоолж, заасан хугацаанд хариуцлагатай ажиллаж тайлагнахыг Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Хагас жилийн малын түүвэр судалгааг арга зүй, удирдлагаар хангаж, ажлын явц байдалд хяналт тавьж ажиллахыг Статистик хариуцсан мэргэжилтэн (А.Хишигбаяр)-г үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГОНЧИГНЯМ



/Zahiramj 2024/